

79

**“ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН ТАВАНТОЛГОЙ-БАРУУННАРАН
ЧИГЛЭЛИЙН 32 КМ АВТО ЗАМЫН ТӨГСГӨЛӨӨС “ЦАГААНДЭЛ УУЛ” ХИЛИЙН БООМТ
ХҮРТЭЛХ 270 КМ АВТО ЗАМ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ-
БАРИХ-АШИГЛАХ-ШИЛЖҮҮЛЭХ (DBOT) КОНЦЕССЫН ГЭРЭЭН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2019 оны 6 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

“Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл Уул” хилийн боомт хүртэлх 270 км авто зам төслийг хэрэгжүүлэх зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх (DBOT) концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг “Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл Уул” хилийн боомт хүртэлх 270 км авто зам төслийг хэрэгжүүлэх зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх (DBOT) концессын гэрээний 5.3 дахь заалт, Эрх бүхий этгээдийн 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн “Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл Уул” хилийн боомт хүртэлх 270 км авто зам төслийг хэрэгжүүлэх зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх (DBOT) концессын гэрээний гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөлийг хянасан тухай болон цаашид авах арга хэмжээний талаарх санал, дүгнэлт, “Ундрах говь” ХХК-ийн 2019 оны 32 дугаар албан тоот хүсэлтийг тус тус үндэслэн нэг талаас Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан;

Нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Ундрах говь” ХХК, түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Н.Батсуурь нар доорх нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

1.1. “Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл Уул” хилийн боомт хүртэлх 270 км авто зам төслийг хэрэгжүүлэх зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх (DBOT) концессын гэрээний 1.26 дахь заалтын “6 сарын” гэснийг “12 сарын” гэж өөрчлөн найруулав.

ХОЁР. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээгээр нэмэлт, өөрчлөлт оруулсан заалтуудаас бусад концессын гэрээний зохицуулалт нь хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

2.2. Энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд концессын гэрээний салшгүй хэсэг байна.

2.3. Энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ нь адил хүчинтэй 3 хувь үйлдэгдсэн бөгөөд төслийн концессын гэрээний хугацаанд хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

Гарын үсэг:

Нэр: Б.Баярсайхан

Албан тушаал: Үндэсний хөгжлийн
газрын дарга

Тамга:

**КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

Гарын үсэг:

Нэр: Н.Батсуурь

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Тамга: